



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 16 өдөр

Дугаар А/57

Номгон


「Аймгийн цэвэр усны нөөцийн худаг шинээр  
барих ажилд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар бүлгийн 2.1.1, 2.1.2, 3 дугаар бүлгийн 3.3, Онцгой комиссын 2021 оны 58 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгийн төв Баянхонгор суманд 2021 оны 07 дугаар сарын 01-08-ны өдрүүдэд тохиолдсон үерийн улмаас аймгийн цэвэр усны нөөцийн худаг бүрэн ажиллагаагүй болж, иргэд олон нийтийг цэвэр усаар хангах үйл ажиллагаа доголдож, эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн тул яаралтай сэргээн засварлах, нөөц худаг шинээр барих ажлыг үүссэн онцгой нөхцөл байдлын улмаас хийж гүйцэтгэх аж ахуйн нэгжийг шууд сонгон шалгаруулж, 3 сарын хугацаанд шуурхай зохион байгуулж, улсын комисст хүлээлгэн өгөхийг “Чандмань-Баянхонгор” ХК-ний захирал, онцгой комиссын гишүүн (М.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

2.Дээрх ажлыг зохион байгуулахтай холбогдон гарах зардалд шаардагдах 117.102.200 (Нэг зуун арван долоон сая нэг зуун хоёр мянга, хоёр зуун) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.



Д.МӨНХСАЙХАН

601210181